

Суралцахын өмнө таны мэдэх ёстой нарийн ширийн зүйлс

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Судлах шүлгүүд	Эдгээр шүлгийг судлахын өмнө таны мэдвэл зохих мэдээлэл
Үйлс 1:23–26	Төлөөлөгчид, мөн Христийн бусад дагалдагч арван хоёр төлөөлөгчийн нэг болох Иудас Искариотын үүргийг хэн орлох талаар ярилцахаар цуглав.
Үйлс 2:37–43	Төлөөлөгчид Христийг Тэнгэр өөд гарснаас хойш удалгүй Иерусалимд цугларах үед Ариун Сүнс тэдний хүн нэг бүрд хүчирхэг аргаар мэдрэгджээ (Үйлс 2:1–8-ыг үзнэ үү). Сүнсээр дүүрсэн Петр Есүс Христийн талаар гэрчилсэн (Үйлс 2:14–36-г үзнэ үү). Судрын энэ хэсэгт уг сүнслэг дүүргэлт үүнийг гэрчилсэн олон хүнд хэрхэн нөлөөлсөн тухай дүрсэлсэн байдаг.
Үйлс 3:1–8; 4:8–10	Петр, Иохан хоёр Иерусалимын ариун сүмийн дэргэд төрөлхийн суунги хүнтэй харц тулгарчээ.
Үйлс 5:12–16	Иудейн удирдагчид Есүс Христийн талаар цаашид ярихгүй байхыг төлөөлөгчдөд өмнө нь сануулсан байв (Үйлс 4:13–18-ыг үзнэ үү).
Үйлс 5:17–25	Петр, Иохан хоёр Есүс Христийн талаар гэрчилж, Түүний нэрээр гайхамшгийг үйлдсээр байсан тул шоронд хоригдсон.

- Та эдгээр шүлгээс Есүс Христэд итгэх итгэл, найдварт тань нөлөөлөх юуг олж мэдсэн бэ?
- Эдгээр үйл явдал Есүс Христ төлөөлөгчдөөрөө дамжуулан Өөрийн Сүмийг удирдаж байсныг хэрхэн харуулдаг вэ?